



# ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ, №21

2017.11.15

**НЭГ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2017 оны 11-р сарын 01-ээс 11-р сарын 15-ны хүртэлх хугацаанд Номхон далайн баруун бүсийн 4 оронд хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.(Хүснэгт 1)

**ХОЁР. 2003 оноос хойш бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл ба нас баралт:**

2003 оноос 2017 оны 11-р сарын 15-ны хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын **860** тохиолдол бүртгэгдсэнээс **454** (52.7%) нь нас барсан бөгөөд сүүлийн тохиолдол 9-р сарын 26-нд Индонези улсад 1 тохиолдол бүртгэгдэж нас барсан байна. 2003 оноос хойш Номхон далайн баруун бүсийн 4 оронд **238** тохиолдол бүртгэгдсэнээс **134** (56%) нь нас барсан байна. Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байна.

**ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2017 оны 11-р сарын 01-ээс 11-р сарын 15-ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2014 оны 5-р сараас хойш БНХАУ-д лабораториор батлагдсан нийт **16** тохиолдлоос **6** (37.5%) нь нас барсан байна.

**Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусын халдварын хүний өвчлөл, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2017.11.15**

| Улс     | 2003-2011 |     | 2012 |   | 2013 |    | 2014 |   | 2015 |   | 2016 |   | 2017 |   | Нийт |     |
|---------|-----------|-----|------|---|------|----|------|---|------|---|------|---|------|---|------|-----|
|         | Т         | Н   | Т    | Н | Т    | Н  | Т    | Н | Т    | Н | Т    | Н | Т    | Н | Т    | Н   |
| Камбожи | 18        | 16  | 3    | 3 | 26   | 14 | 9    | 4 | 0    | 0 | 0    | 0 | 0    | 0 | 56   | 37  |
| Хятад   | 41        | 27  | 2    | 1 | 2    | 2  | 2    | 0 | 6    | 1 | 0    | 0 | 0    | 0 | 53   | 31  |
| Лаос    | 2         | 2   | 0    | 0 | 0    | 0  | 0    | 0 | 0    | 0 | 0    | 0 | 0    | 0 | 2    | 2   |
| Вьетнам | 119       | 59  | 4    | 2 | 2    | 1  | 2    | 2 | 0    | 0 | 0    | 0 | 0    | 0 | 127  | 64  |
| Нийт    | 180       | 104 | 9    | 6 | 30   | 16 | 13   | 6 | 6    | 1 | 0    | 0 | 0    | 0 | 238  | 134 |

**ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2017 оны 11-р сарын 01-ээс 11-р сарын 15-ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2013 оноос хойш шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн нийт **1564** тохиолдол лабораториор батлагдсан.

*Албан ёсны эх сурвалж:*

- [http://www.who.int/influenza/human\\_animal\\_interface/H5N1\\_cumulative\\_table\\_archives/en/index.html](http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html)
- [http://www.who.int/influenza/human\\_animal\\_interface/EN\\_GIP\\_20140727CumulativeNumber\\_H5N1cases.pdf](http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber_H5N1cases.pdf)
- [http://www.wpro.who.int/outbreaks\\_emergencies/H7N9/en/index.html](http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html)
- [http://www.who.int/influenza/human\\_animal\\_interface/influenza\\_h7n9/en/index.m](http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m)
- [http://www.wpro.who.int/emerging\\_diseases/aiweekly\\_465\\_09jan2015.pdf?ua=1](http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1)
- <http://empres-i.fao.org/eipws3g/#h=0>

**ЗӨСҮТ**

**ЭУББТСТ**

**ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ**